



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар СХШ-2025/20

Сүхбаатар сум

Орхон сумын Засаг даргын Тамгын  
Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн  
хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 09 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Орхон сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т. Мөнхзул 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Орхон сумын Засаг даргын Тамгын газрын (цаашид Орхон сумын ЗДТГ гэх)-ын 2023, 2024 онуудын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Орхон сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 9055959 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130555001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130555408 дугаартай дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Орхон сумын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга Ш.Ганчимэг, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Хүдэрчулуун, Л.Сэлэнгэмөрөн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Орхон сумын ЗДТГ нь улс төрийн албан тушаалтан 2, төрийн захиргааны албан хаагч 9, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 7, гэрээт албан хаагч 2 нийт 20 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

## Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

### 2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Сумын ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

### 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

#### 2.2.1 Батлагдсан төсөв:

2023 онд орон нутгийн төсвөөс 762,903.6 мянган төгрөгөөр 2024 онд 882,994.7 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 2023 онд 699,774.8 мянган төгрөгийг буюу 91.7 хувийг, 2024 онд 784,286.9 мянган төгрөгийг буюу 88.8 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

/мян.төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт -/-	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт -/-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	762,903.6	699,774.8	63,128.8	882,994.7	784,286.9	98,707.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	573,301.0	511,346.4	61,954.6	859,045.1	760,337.3	98,707.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	563,532.1	503,597.6	59,934.5	780,630.1	713,665.1	66,965.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,779.3	334,079.1	29,700.2	521,260.0	479,277.6	41,982.4
210101	Үндсэн цалин	228,889.8	232,140.1	-3,250.3	323,250.0	303,842.4	19,407.6
210102	Нэмэгдэл	134,889.5	101,938.9	32,950.6	181,010.0	162,592.8	18,417.2
210104	Урамшуулал	0.0	0.0	0.0	17,000.0	12,842.5	4,157.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,970.3	43,962.0	2,008.3	71,840.5	61,519.6	10,320.9
210201	Тэтгэврийн даатгал	31,245.0	30,595.6	649.4	50,036.0	42,784.3	7,251.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,678.5	3,599.5	79.0	4,360.5	4,537.3	-176.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,942.1	2,706.5	235.6	5,736.3	4,012.2	1,724.1
210204	Ажилгүйдлийн даатгал	742.0	640.3	101.7	1,064.7	1,093.9	-29.2
210205	Эрүүл мэндийн даатгал	7,362.7	6,420.1	942.6	10,643.0	9,091.9	1,551.1

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>50,276.6</b>	<b>35,280.6</b>	<b>14,996.0</b>	<b>78,000.0</b>	<b>74,434.5</b>	<b>3,565.5</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,830.0	4,507.4	322.6	17,000.0	16,484.9	515.1
210302	Түлш, халаалт	45,086.6	30,653.1	14,433.5	61,000.0	57,949.6	3,050.4
210303	Цэвэр, бохир ус	360.0	120.0	240.0	0.0	0.0	0.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,374.6</b>	<b>34,178.7</b>	<b>2,195.9</b>	<b>37,199.0</b>	<b>36,509.2</b>	<b>689.8</b>
210401	Бичиг хэрэг	3,258.1	3,080.6	177.5	5,200.0	5,139.3	60.7
210402	Тээвэр, шатахуун	25,388.0	25,387.9	0.1	22,500.0	22,500.0	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,846.3	2,878.0	968.3	3,300.0	2,869.9	430.1
210404	Ном, хэвлэл	0.0	0.0	0.0	199.0	0.0	199.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200.0	150.0	1,050.0	0.0	0.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,682.2	2,682.2	0.0	6,000.0	6,000.0	0.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>359.6</b>	<b>274.0</b>	<b>85.6</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	359.6	274.0	85.6	0.0	0.0	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,266.3</b>	<b>9,623.9</b>	<b>642.4</b>	<b>18,400.6</b>	<b>12,972.5</b>	<b>5,428.1</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,696.9	1,203.4	493.5	0.0	0.0	0.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	583.7	441.0	142.7	1,000.0	1,000.0	0.0
210604	Урсгал засвар	7,985.7	7,979.5	6.2	17,400.6	11,972.5	5,428.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,638.7</b>	<b>3,719.0</b>	<b>1,919.7</b>	<b>3,940.0</b>	<b>3,864.0</b>	<b>76.0</b>
210702	Дотоод албан томилолт	5,638.7	3,719.0	1,919.7	3,940.0	3,864.0	76.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,907.7</b>	<b>8,670.3</b>	<b>5,237.4</b>	<b>19,940.0</b>	<b>15,433.9</b>	<b>4,506.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,831.1	7,006.9	3,824.2	8,900.0	6,454.6	2,445.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	239.8	0.0	239.8	200.0	0.0	200.0
210803	Даатгалын үйлчилгээ	613.5	118.8	494.7	632.0	215.3	416.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	370.9	214.6	156.3	1,500.0	557.9	942.1

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	173.4	165.0	8.4	288.0	66.0	222.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,170.9	1,165.0	5.9	8,000.0	7,740.0	260.0
210807	Газрын төлбөр	400.2	0.0	400.2	400.0	400.0	0.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17.5	0.0	17.5	0.0	0.0	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90.4	0.0	90.4	20.0	0.0	20.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>36,959.0</b>	<b>33,810.1</b>	<b>3,148.9</b>	<b>30,050.0</b>	<b>29,653.8</b>	<b>396.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,784.0	32,740.1	3,043.9	28,700.0	28,303.8	396.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,175.0	1,070.0	105.0	1,350.0	1,350.0	0.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,768.9</b>	<b>7,748.8</b>	<b>2,020.1</b>	<b>78,415.0</b>	<b>46,672.2</b>	<b>31,742.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,768.9</b>	<b>7,748.8</b>	<b>2,020.1</b>	<b>78,415.0</b>	<b>46,672.2</b>	<b>31,742.8</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368.7	7,748.8	619.9	38,400.0	12,870.0	25,530.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	0.0	30,000.0	23,815.2	6,184.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400.2	0.0	1,400.2	10,015.0	9,987.0	28.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>189,602.6</b>	<b>188,428.4</b>	<b>1,174.2</b>	<b>23,949.6</b>	<b>23,949.6</b>	<b>0.0</b>
220001	Барилга байгууламж	121,142.8	121,142.8	0.0	0.0	0.0	0.0
222001	Тоног төхөөрөмж	68,459.8	67,285.6	1,174.2	20,000.0	20,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	0.0	0.0	0.0	3,949.6	3,949.6	0.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>762,903.6</b>	<b>699,774.8</b>	<b>63,128.8</b>	<b>882,994.7</b>	<b>784,286.9</b>	<b>98,707.8</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.0</b>	<b>698,030.8</b>	<b>-698,030.8</b>	<b>0.0</b>	<b>782,259.4</b>	<b>-782,259.4</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.0	698,030.8	-698,030.8	0.0	782,259.4	-782,259.4
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>454,443.0</b>	<b>0.0</b>	<b>454,443.0</b>	<b>882,364.8</b>	<b>0.0</b>	<b>882,364.8</b>
320001	Орон нутгийн төсвөөс	454,443.0	0.0	454,443.0	882,364.8	0.0	882,364.8
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНА АС</b>	<b>308,460.6</b>	<b>1,744.0</b>	<b>306,716.6</b>	<b>629.9</b>	<b>2,027.5</b>	<b>-1,397.6</b>

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	1,744.0	-1,744.0	629.9	2,027.5	-1,397.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.0	0.0	500.0	0.0	0.0	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	307,960.6	0.0	307,960.6	0.0	0.0	0.0

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас зарцуулалтыг зардлын ангилал бүрээр шалгаж дүгнэхэд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** нийт төсвийн 2023 онд 363,779.3 мянган төгрөг 2024 онд 521,260.0 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөснөөс 2023 онд 334,079.1 мянган төгрөгийг зарцуулж 29,700.2 мянган төгрөгийг хэмнэж 2024 онд 479,277.6 мянган төгрөгийг зарцуулж 41,982.4 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь зарим сард орон тоо гүйцэд биш ажилласнаас шалтгаалсан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:** 2023 онд 50,276.6 мянган төгрөг батлагдсанаас гэрэл цахилгааны зардал 4,507.4 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 30,653.1 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 120.0 мянган төгрөг зарцуулж, 14,996.0 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 78,000.0 мянган төгрөг батлагдсанаас гэрэл цахилгааны зардал 16,484.9 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 57,949.6 мянган төгрөг зарцуулж, 3,565.5 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.
- Хангамж бараа материалын зардал:** 2023 онд хангамж, бараа материалын зардалд 36,374.6 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 3,080.6 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 25,387.9 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 2,878.0 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 150.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 2,682.2 мянган төгрөг зарцуулж 2,195.9 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд хангамж, бараа материалын зардалд 37,199.0 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 5,139.3 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 22,500.0 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 2,869.9 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 6,000.0 мянган төгрөг зарцуулж 689.8 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.
- Нормативт зардал:** 2023 онд 359.6 мянган төгрөг батлагдаж 274.0 мянган төгрөг зарцуулж, 85.6 мянган төгрөг хэмнэлттэй, 2024 онд тус зардалд төсөв батлагдаагүй байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал:** 2023 онд 10,266.3 мянган төгрөг батлагдаж багаж, техник хэрэгслийн зардалд 1,203.4 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 441.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 7,979.5 мянган төгрөг зарцуулж, 642.4 мянган төгрөг хэмнэж, 2024 онд 18,400.6 мянган төгрөг батлагдаж хөдөлмөр хамгааллын

- хэрэгслийн зардалд 1,000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 11,972.5 мянган төгрөг зарцуулж 5,428.1 мянган төгрөгийг хэмнэжээ
6. **Томилолтын зардал:** 2023 онд 5,638.7 мянган төгрөг батлагдаж 3,719.0 мянган төгрөгийг зарцуулж 1,919.7 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 3,940.0 мянган төгрөг батлагдаж 3,864.0 мянган төгрөг зарцуулж 76.0 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.
  7. **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2023 онд 13,907.7 мянган төгрөг батлагдсанаас 8,670.3 мянган төгрөг зарцуулж 5,237.4 мянган төгрөг хэмнэсэн, 2024 онд 19,940.0 мянган төгрөг батлагдаж 15,433.9 мянган төгрөг зарцуулж 4,506.1 мянган төгрөг хэмнэсэн байна.
  8. **Бусад зардал:** 2023 онд 36,959.0 мянган төгрөг батлагдаж бараа үйлчилгээний бусад зардалд 32,740.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 1,070.0 мянган төгрөг зарцуулж 3,148.9 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 30,050.0 мянган төгрөг батлагдаж бараа үйлчилгээний бусад зардалд 29,303.8 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 1,350.0 мянган төгрөг зарцуулж 396.2 мянган төгрөг хэмнэсэн байна.
  9. **Урсгал шилжүүлгийн зардал:** 2023 онд 9,768.9 мянган төгрөг батлагдсанаас төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардалд 7,748.8 мянган төгрөг зарцуулж 619.9 мянган төгрөг хэмнэлттэй, 2024 онд 78,415.0 батлагдаж төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардалд 12,870.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 23,815.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 9,987.0 мянган төгрөг зарцуулж 31,742.8 мянган төгрөг хэмнэжээ.

**2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:** Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДТГ-аас 3,202.9 мянган төгрөгийн, Статистикийн хэлтсээс 1,038.5 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,920.0 мянган төгрөг болон бусад 73,931.3 мянган төгрөг зэрэг нийт 80,092.7 мянган төгрөгийн орлогыг дараах зардлуудад зарцуулсан байна.

Үүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 789.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 8,908.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 4,860.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 25,400.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 40,067.4 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 67.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## **2.3 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт**

Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн боловч үндсэн хөрөнгийн засварыг капиталжуулахгүй засвар нэрээр бүртгэсэн, элэгдлээр бүрэн нөхсөн хөрөнгүүдийн судалгаа гаргаж данснаас хасах буюу дахин үнэлж бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтлөхгүй байгаа нь санхүүгийн тайлан, мэдээлэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна. Иймд дээрх бүртгэлийн алдааг залруулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

### **Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал**

Орхон сумын ЗДТГ-ын 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй гүйлгээ хийх, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулах, тээврийн хэрэгслэлийн 100 км гүйлтэд зарцуулах норм баримтлаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

**Илрүүлэлт 1.** Үндсэн хөрөнгийн дансны ангилал болон хөрөнгийн нэршлийг ерөнхий утгаар бүртгэсэн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон ОНӨГ-ын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 5.1.5 дах “хэмжигдэхүйц байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцож судалгааг гарган дахин үнэлэх шаардлагатай хөрөнгүүдийг холбогдох шатны байгууллагаар шийдвэрлүүлж үндсэн хөрөнгийн барилга байгууламжинд бүртгэлтэй хөрөнгийн данс хоорондох алдааг залруулах зөвлөмж хүргүүлэв.

**Илрүүлэлт 2.** Төрийн сангийн гүйлгээг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан баталгаажсан цалин олгох хүснэгт, ажилтнуудын цагийн бүртгэл, холбогдох тушаал, шийдвэр зэрэг цалин олголтыг үндэслэх анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад ажил гүйлгээг гүйцэтгэж, уг төлбөрийг санхүүгийн бүртгэл, тайланд тусгасан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх”, 24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан

авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно., Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно., 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдлийг хянан, хүчин төгөлдөр анхан шатны баримтаар гүйлгээ хийх зөвлөмж хүргүүлэв.

**Илрүүлэлт 3.** Тээврийн хэрэгслэлийн 100 км гүйлтэд зарцуулах норм баримтлаагүй жолоочийн тооцооны хуудасны маяганд явсан заалтыг бичихгүй дутуу бөглөж ажилд гарсан тухай бүрт нь хөтлүүлээгүй 2024 онд **23,617.0** мянган төгрөгийн шатахуун олгож зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг, Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралт дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсыг ажилд гарсан тухай бүрд нь километрийн заалтыг бичүүлж шатахууныг сар бүр тооцож тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

**Илрүүлэлт 4.** Сумын наадмын зардлыг байгууллагын дансаар бус, няравын хувийн дансаар дамжуулан зарцуулсан 7,350.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дэх "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2023 оны 444 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журамын 3.1.1-т "Төрийн сангийн нэгдсэн дансыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуулийн 38.1.1-д заасны дагуу удирдах бөгөөд нэгдсэн данс нь мөн хуулийн 35.1-д заасны дагуу Монгол банканд байршина" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид няравын дансаар дамжуулж бэлэн мөнгө гаргахгүй тухайн төлбөр тооцоог нэхэмжлэлийн дагуу шилжүүлэг хийж байх зөвлөмж хүргүүлэв.

**Илрүүлэлт 5.** Улирал бүр үр дүнгийн урамшуулал авч байгаа боловч 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр сум сайн дүгнэгдсэн шалтгаанаар тамгын газрын

дарга, ерөнхий нягтлан бодогч нарт 2,917.0 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг зардлаас, мөн ерөнхий нягтлан, тооцооны 2 нягтлан бодогчид 5,120.0 мянган төгрөгийг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас, нийт 8,034.0 мянган төгрөгийг тус тус давхардуулан олгосон байна.

Энэ нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3.3 дахь "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид шагнал олгох журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 6.** Газрын төлбөрийн зардлаас газрын хэмжилт хийлгэсэн ажлын хөлсөнд 4,000.0 мянган төгрөгийг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 2,917.0 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлагыг хүргүүлэв.

## **Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

### **4.1 Дүгнэлт:**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Орхон сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

### **4.2 Шийдвэрлэлт:**

Орхон сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **45,918.0** мянган төгрөгийн **6** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын

улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох **8,034.0** мянган төгрөгийн 1 албан шаардлага, 37,884.0 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:**

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2026 оны 03 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮ  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН.

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Ш.ГАНЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Л.СЭЛЭНГЭМӨРӨН

